



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 270

Улаанбаатар хот

“Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг
бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт
тавих журам” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 13.1.3, “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”-ын 2 дугаар бүлгийн Б хэсгийн заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос **ТОГТООХ** нь:

1. “Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/-т, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-т тус тус даалгасугай.

ДАРГА

Д. БАЯРСАЙХАН

ДАВХАР ДААТГАГЧИЙН АЛДАГДЛААС ХАМГААЛАХ САНГ БҮРДҮҮЛЭХ, ЗАРЦУУЛАХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2 дахь заалтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд (цаашид “давхар даатгагч” гэх)-ийн алдагдлаас хамгаалах сан (цаашид “алдагдлаас хамгаалах сан” гэх)-г бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавихад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Алдагдлаас хамгаалах сангийн зорилго нь даатгалын зах зээлийн тогтвортой хөгжлийг хангах, даатгуулагч болон давхар даатгуулагчдын эрх ашгийг хамгаалах, давхар даатгуулагч нарт алдагдлаас хамгаалах сангаас даатгалын гэрээний дагуу олгох нөхөн төлбөрийн шаардлагыг хангахад тус сангийн хөрөнгийг хүрэлцэхүйц, баталгаатай байлгахад оршино.

ХОЁР. Алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлт

2.1. Давхар даатгагч даатгалын хохирлыг нөхөн төлөх нөөц сан хүрэлцэхгүй болсон тохиолдолд ашиглах зориулалт бүхий алдагдлаас хамгаалах санг байгуулна.

2.2. Алдагдлаас хамгаалах сан нь мөнгөн хөрөнгөөс бүрдэх бөгөөд түүний доод хэмжээ нь 15 тэрбум төгрөг байна. Алдагдлаас хамгаалах санг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

2.3. Алдагдлаас хамгаалах сангийн 5 тэрбум төгрөгийг эхний давхар даатгалын гэрээ байгуулахаас өмнө энэ журмын 3.1-д заасны дагуу байршуулна. Үлдэх 10 тэрбум төгрөгийг Хорооноос тусгай зөвшөөрөл авснаас хойш 3 жилийн дотор, үүнээс 5 тэрбум төгрөгийг эхний нэг жилийн дотор бүрдүүлж, энэ журмын 3.3-т заасны дагуу байршуулна.

ГУРАВ. Алдагдлаас хамгаалах сангийн байршил, хөрөнгө оруулалт

3.1. Энэхүү журмын 2.2-т заасан алдагдлаас хамгаалах сангийн доод хэмжээний 1/3 хэсгийг Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан, компанийн тухай хуулийн 99.1-т заасан компанийн нэгдмэл сонирхолтой этгээдэд хамаарах банкнаас бусад банкинд байршуулна. Алдагдлаас хамгаалах сангийн үлдэх 2/3 хэсгийг хөрөнгө оруулалт хэлбэрээр байршуулж болно.

/Энэ хэсгийг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 03 дугаар сарын 04-ний 47-р тогтоолоор өөрчлөн найруулсан/

3.2. Алдагдлаас хамгаалах сангийн доод хэмжээний 1/3 хэсэг буюу 5 тэрбум төгрөгийг дөрвөөс доошгүй банкинд тараан байршуулна. Нэг банкинд байршуулах мөнгөн хөрөнгийн дээд хязгаар нь дээрх мөнгөн дүнгийн 25 хувиас хэтэрч болохгүй.

3.3.Алдагдлаас хамгаалах сангийн доод хэмжээний 10 тэрбум төгрөгийг дор дурдсан хувь хэмжээгээр Монгол Улсын нутаг дэвсгэр дэх хөрөнгө оруулалтад байршуулж болно.

3.3.1.Банкны хадгаламж: 100 хүртэл хувь (нэг банкинд 20 хүртэл хувь);

3.3.2.Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь (нэг банкинд 20 хүртэл хувь);

3.3.3.Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;

3.3.4.Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;

3.3.5.Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;

3.3.6.Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 20 хүртэл хувь;

3.3.7.Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;

3.3.8.Компанийн бонд: 10 хүртэл хувь (нэг компанид 5 хүртэл хувь);

3.3.9.Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь;

3.3.10. Даатгалын тухайн хуулийн 4.1.12-д заасан “холбогдох этгээд”-ээс бусад этгээдэд Даатгалын тухай хуулийн 27.1.3-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь;

/Энэ заалтыг Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 202 дугаар тогтоолоор өөрчилөн найруулсан/

3.3.11.Үл хөдлөх хөрөнгө: 10 хүртэл хувь (үндсэн үйл ажиллагаа явуулдаг ажлын байрнаас бусад).

3.4.Энэ журмын 3.3.11-т заасны дагуу үл хөдлөх хөрөнгөнд хөрөнгө оруулсан нөхцөлд хөрөнгийн үнэлгээг 3 жил тутамд шинэчлэн хийх ба хөрөнгийн үнэлгээнд Хороо жил бүр хяналт тавина.

ДӨРӨВ. Алдагдлаас хамгаалах сангийн зарцуулалт

4.1.Давхар даатгуулагчаас даатгалын гэрээний дагуу нэхэмжилсэн даатгалын нөхөн төлбөрийг давхар даатгагчийн хохирол төлөх нөөц сангаас төлж хүрэлцэхгүй болсон тохиолдолд зөрүүг алдагдлаас хамгаалах сангаас олгоно.

4.2.Алдагдлаас хамгаалах санг энэ журмын 3 болон 4.1-д зааснаас өөрөөр ашиглахыг хориглоно.

4.3.Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөрийг олгосон тохиолдолд нөхөн төлсөн төлбөрийн дүнтэй уялдуулан алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн дахин бүрдүүлэлтийг дараах байдлаар хийнэ:

4.3.1.Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн 5 тэрбум төгрөг хүртэл бол уг хөрөнгийг 1 жилийн дотор;

4.3.2.Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн 5-аас 10 тэрбум төгрөг хүртэл бол 2 жилийн дотор, үүнээс 5 тэрбум төгрөгийг эхний нэг жилийн дотор, үлдэх хэсгийг дараагийн нэг жилийн дотор;

4.3.3.Алдагдлаас хамгаалах сангаас олгосон нөхөн төлбөрийн дүн 10-аас 15 тэрбум төгрөг бол 2 жилийн дотор, үүнээс эхний 5 тэрбум төгрөгийг 1 сарын дотор, үлдэх хэсгийг энэ журмын 4.3.2-т заасны дагуу тус тус дахин бүрдүүлнэ.

4.4.Алдагдлаас хамгаалах сангаас нөхөн төлбөр олгох болсон тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороонд 7 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

ТАВ. Алдагдлаас хамгаалах санд тавих хяналт, хариуцлага

5.1.Алдагдлаас хамгаалах сангийн бүрдүүлэлт, зарцуулалтанд Санхүүгийн зохицуулах хороо улирал тутам хяналт тавина.

5.2.Алдагдлаас хамгаалах сангийн хөрөнгийн байршил, хөрөнгө оруулалтыг энэхүү журмын хавсралт маягтын дагуу гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд улирал бүр ирүүлнэ.

5.3.Энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

--ooOoo--

“Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын хавсралт

Алдагдлаас хамгаалах сангийн байршил, хөрөнгө оруулалт

(мянган төгрөг)

№	Зүйл	Хөрөнгийн хэмжээ	Хувь
1	Заавал байршуулах нөөц (Алдагдлаас хамгаалах сангийн 1/3)		
1.1	“..... банк”		
1.2	“..... банк”		
1.3	“..... банк”		
1.4	“..... банк”		
2	Хөрөнгө оруулалт хийж болох мөнгөн хөрөнгө (Алдагдлаас хамгаалах сангийн 2/3)		
2.1	Банкны хадгаламж: 100 хүртэл хувь		
2.1.1	“..... банк”		
2.1.2	“..... банк”		
2.1.3	“..... банк”		
2.1.4	“..... банк”		
2.1.5	“..... банк”		
2.2	Банкны харилцах дансанд байршуулах: 100 хүртэл хувь		
2.2.1	“..... банк”		
2.2.2	“..... банк”		
2.2.3	“..... банк”		
2.2.4	“..... банк”		
2.2.5	“..... банк”		
2.3	Засгийн газрын өрийн бичиг: 100 хүртэл хувь;		
2.4	Төв банкны үнэт цаас: 60 хүртэл хувь;		
2.5	Орон нутгийн засаг захиргааны бонд: 20 хүртэл хувь;		
2.6	Үл хөдлөх хөрөнгөөр барьцаалсан үнэт цаас 20 хүртэл хувь;		
2.7	Банкны хадгаламжийн сертификат: 10 хүртэл хувь;		
2.8	Компанийн бонд: 10 хүртэл хувь;		
2.8.1	“..... ” ХК, ХХК		
2.8.2	“..... ” ХК, ХХК		
2.9	Санхүүгийн болон үйл ажиллагааны лизинг: 5 хүртэл хувь		
2.10	Үл хөдлөх хөрөнгө барьцаалсан арилжааны богино хугацаат (нэг жил хүртэл) зээл 5 хүртэл хувь		
2.11	Үл хөдлөх хөрөнгө: 5 хүртэл хувь (Үндсэн үйл ажиллагаа явуулдаг ажлын байрнаас бусад)		
3	НИЙТ ДҮН		